

2022 ОНЫ 8 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутаг тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- **Баруун** (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- **Төв** (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул)
- **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- **Говь** (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "бүх нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.

Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 11–326606 утсаар холбогдох болон "Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн "Орчил урсгал, урт хугацааны прогнозын судалгааны хэлтэс"–ээс тодруулах боломжтой.

НАЙМДУГААР САРЫН ХҮЙТЭН ШӨНИЙН ДАВТАГДАЛ


Зураг 1–т 1981–2020 оны наймдугаар сард тохиолдсон хүйтэн шөнийн (**ХШ** [Cold night]: Агаарын хамгийн бага температур олон жилийн дундаж (1991–2020) утгаас хүйтэн байсан хоногийн тоо) тохиолдлын тоог үзүүлэв. Зургаас харахад наймдугаар сард баруун аймгуудын ихэнх, төв болон говийн аймгуудын нутгийн зарим газраар 94.6–149.3 хүртэл буюу харьцангуй олон **ХШ** тохиолдсон байхад бусад нутгаар 40.0–67.3 удаа тохиолдсон байна. Харин 2000 оноос хойш **ХШ**–ийн тохиолдлын тоо (зураг 1б) харьцангуй цөөн өртөөг хамарсан байна.



Зураг 1. 1981–2020 оны наймдугаар сарын хүйтэн шөнийн тохиолдлын тоо а) 1981–1999, б) 2000–2020


УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Наймдугаар сарын агаарын температурын ОЖД нь Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Ховдын төв, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр +8...+12°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорнодын өмнөд хэсэг болон Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар +20...+24°C, бусад нутгаар +12...+20°C дулаан байдаг байна (**Зураг 2**).




Зураг 2. 8-р сарын агаарын температурын ОЖД, [°C].

Наймдугаар сарын агаарын дундаж температур 2001–2002, 2005–2008, 2011, 2015, 2016, 2018 онуудад ОЖД-аас 1–3°C-аар дулаан байж, өдөртөө төв, зүүн, говийн аймгуудын нутгаар 36–40°C хүрч халж байв. Харин 1980–1999 онуудад ОЖД-аас хүйтэн жилүүд үргэлжилж байсан бол 2003, 2004, 2010, 2012, 2017 онууд болон 2020, 2021 онуудад ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн байсан байна (**Зураг 3**).



Зураг 3. 8-р сарын агаарын температурын олон жилийн явц


[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]



Сарын нийлбэр хур танадас ОЖД-аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтийн хойд, Дорнодын хойд болон зүүн хэсгээр 60–100 мм, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр 0–20 мм, бусад нутгаар 20–60 мм хур тунадас ордог (**Зураг 4**).

Зураг 4. 8-р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм].

Зарим жил ОЖД-аас хэд дахин их болон бага хур тунадас орох тохиолдол цөөнгүй байдаг. Тухайлбал, 198–1984, 1987, 1988, 1990–1995, 1998, 2000, 2007, 2012, 2013, 2017, 2018, 2020, 2021 онуудад зарим нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон бол 2001, 2002, 2004, 2006, 2008, 2011, 2014, 2016, 2019 онууд харьцангуй бага хур тунадастай байсан байна (Зураг 5).



Зураг 5. 8-р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц

[Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Баруун аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур ихэнх нутгаар ОЖД-ийн орчим, харин Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД-аас дулаан (Зураг 6), хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (Зураг 7).

Агаарын температур, хур тунадасны явцыг (Зураг 8)-д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар ОЖД-аас 1–2°C-аар дулаан байх бол, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ОЖД-аас 1–2°C-аар хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар бороо орно. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө түр зуур ширүүснэ.

Төвийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-ийн орчим (Зураг 6), хур тунадас Сэлэнгийн зүүн хэсэг болон Төв аймгийн зүүн хагаст ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (Зураг 7).

Агаарын температур, хур тунадасны явцыг (Зураг 9)-д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар ОЖД-аас 1–

2°C–аар дулаан байх бол, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ОЖД–аас 1–2°C–аар хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар бороо орно. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө түр зуур ширүүснэ.

Зүүн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим (**Зураг 6**), хур тунадас Хэнтийн нутгаар ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 7**).


Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 10**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар ОЖД–аас 1–2°C–аар дулаан байх бол, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ОЖД–аас 1–2°C–аар хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар бороо орно. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө түр зуур ширүүснэ.


Говийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Өмнөговь, Дорноговийн нутаг, Дундговийн өмнөд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим (**Зураг 6**), хур тунадас нийт нутгаар ОЖД–ийн орчим байх төлөлтэй байна (**Зураг 7**).

Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 11**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас 1–2°C–аар дулаан байх бол, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ОЖД–аас 1–2°C–аар хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр болон гуравдугаар арав хоногийн эхэн үеэр ихэнх нутгаар бороо орно. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө түр зуур ширүүснэ.




Зураг 6. 2022 оны 8-р сарын агаарын дундаж температурын урьдчилсан мэдээ, С⁰
 [Д-агаарын температур ОЖД-аас дулаан, Н-агаарын температур ОЖД-ийн орчим]



Зураг 7. 2022 оны 8-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан мэдээ, мм


[И-хур тунадас ОЖД-аас ахиу, Н-хур тунадас ОЖД-ийн орчим]



Зураг 8. Баруун аймгуудын нутгийн 2022 оны 8-р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,


үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 9. Төвийн аймгуудын нутгийн 2022 оны 8-р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,


үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 10. Зүүн аймгуудын нутгийн 2022 оны 8-р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,

үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 11. Говийн аймгуудын нутгийн 2022 оны 8-р сарын температур, хур тунадасны явц

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,

үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]

ЗӨВЛӨМЖ

Наймдугаар сард нутгийн зүүн болон өмнөд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Харин хур тунадас ихэнх нутгаар ОЖД–ийн орчим байх ба Хэнтий нуруу орчмоор олон жилийн дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй байгаа тул гэнэтийн аадар бороо орох, гол мөрний усны түвшин нэмэгдэж, богино хугацаанд үерлэх магадлал өндөр тул голын эрэг дагуу суурьшиж, нутаглаж буй малчид, ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, аялал зугаалгаар яваа хүмүүс үер усны аюулаас болгоомжтой байхыг онцгойлон анхааруулж байна.